

## ГЛОБАЛ ГАДААД ОРЧИН: МОНГОЛ УЛС БА ЭДИЙН ЗАСГИЙН УЛАМЖЛАЛТ БУС АЮУЛ, ТҮҮНИЙ СОРИЛТ

*Ц.Баатар\**

Глобалчлалын өнөөгийн эринд уламжлалт бус аюул занал хүрээгээ тэлж, дэлхийн улс орон, бүс нутгуудад улам бүр хурцдаж буй тулгамдсан асуудал болж, хүн ардын сэтгэлийг ихээхэн түгшээх боллоо. Монгол Улс болон ЗХА-ийн бүс нутагт ч гэсэн мөн нэгэн адил ийм аюул занал нүүрлэж, түгшүүр төрүүлж байгааг улс төрчид, судлаач, шинжээчид олонтаа анхааруулсаар байна. Бий болсон хурцадмал нөхцөл байдалтай уялдан Зүүн, Зүүн Өмнөд Азийн орнуудыг хамарсан уламжлалт бус аюулын талаар судалгааны нэгдсэн сүлжээ бий болгох чиглэлд бүс нутгийн орнууд ихээхэн ач холбогдол өгч, хөрөнгө хүч гаргаж, олон улсын эрдэм шинжилгээний хурал жил бүр зохион байгуулж, үр дүнг бүс нутгийн орнуудын засгийн газар, олон улсын байгууллагын хүрээнд, янз бүрийн түвшинд тогтмол авч хэлэлцдэг уламжлал тогтож эхэллээ.

Зүүн Өмнөд Азийн Сингапур, Малайз, Филиппин, Индонези, Тайланд зэрэг орнууд уламжлалт бус аюулын чиглэлээр дагнасан судалгааны бие даасан нэгж байгууллаа.

Уламжлалт бус аюулын чиглэлээр улс орон, бүс нутгийн хэмжээнд явуулж буй судалгааны төслүүдийг дэмжин санхүүжүүлэхэд Ford Foundation, Woodrow Wilson Center, Brookings, Center for Global Development зэрэг дэлхийд нэр хүндтэй судалгааны төвүүд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна.

Өнөөдөр уламжлалт аюулаасаа уламжлалт бус аюул илүү хор хөнөөлтэй гэж дэлхий нийт үзэж байна. Манайд энэ талаар гарсан судалгааны ганц нэг өгүүлэл ч болов үзэхийг хичээсэн боловч харамсалтай нь олж харсангүй. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд ч энэ асуудлыг тухайлан авч үзсэн зүйл харагдсангүй. Энэ бүхнээс үзэхэд уламжлалт бус аюулд манайх төдийлэн ач холбогдол өгөхгүй байгаа мэт сэтгэгдэл төрүүлж буй тул энэ тулгамдсан хурц асуудалд төр засаг, улс төрчид, судлаач шинжээчид болон олон нийтийн анхаарлыг хандуулах үүднээс энэхүү бэсрэг өгүүллийг тэрлэв.

Монголд нүүрлэж буй уламжлалт бус аюул глобал гадаад орчны нөлөөгөөр хүссэн хүсээгүй бүс нутгийг ч хамрах тул энэ асуудлыг ЗХА-ийн бүс нутгийн хэмжээнд авч үзэх оролдлого хийлээ.

\* Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Юуны өмнө, Монгол орон өнөөдөр чухам яагаад бүс нутаг хийгээд дэлхий нийтийн анхаарал сонирхолын төвд татагдан орох болсныг уламжлалт бус аюулын багц асуудлын хүрээнд хураангуйлан авч үзье.

Энэ маань мэдээж хэрэг, нэг талаас уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн байгаа орчинд нүүрлэж буй аюул, нөгөө талаас Монголын эрдэс баялгийн асар их нөөцийг эргэлтэнд оруулж ашиглахтай холбогдсон их гүрнүүдийн өрсөлдөөн, түүнээс гарч болох сөрөг үр дагавар, эдийн засаг, нийгмийн асуудал юм.

Өнгөрсөн зууны 90-ээд оноос хойш хөгжингүй болон бүс нутгийн орнууд, олон улсын санхүүгийн байгууллагууд Монгол Улсыг Азийн анхны ардчилсан, нээлттэй зах зээлийн шилжилтийн эдийн засагтай, сул хөгжсөн, эдийн засгийн багтаамж бага, хоёр их гүрний хооронд хавчуулагдсан байрлалтай оршдог, далайд гарцгүй гэх мэт хүчин зүйлсийг тусламж үзүүлэх болон хамтын ажиллагаанд гол үзүүлэлт болгож ирсэн билээ.

Тэгвэл өнөөдөр Монгол Улсыг харилцан хамааралтай глобал гадаад орчин болон бүс нутгийн уламжлалт бус аюулын хүрээнд шинээр авч үзэх, Монголын талаархи хэвшсэн үзэл баримтлалаа өөрчлөх зайлшгүй бодит шаардлага нэгэнт бий болсныг хэлэх нь зүйд нийцэх биз ээ.

Монгол Улс өнөөдөр байгалийн эрдэс баялгийн стратегийн асар нөөц бүхий дэлхийн 10 улсын тоонд багтаж, эрчим хүчний гол эх үүсвэр болох уран, нүүрсний орд газрын нөөцөөр бүс нутагтаа тэргүүлэх орнуудын нэгэнд зүй ёсоор орж байна. Гэтэл ЗХА-ийн Хятад, Япон, Солонгос зэрэг дэлхийн хэмжээний эдийн засагтай орнуудад эрчим хүчний хомсдол нүүрлээд байгаа билээ. Зөвхөн Хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжил нь эрчим хүчний асар их хэрэгцээг бий болгож, жилд дундажаар 70-80 мянган мВт эрчим хүчний нэмэлт хэрэгцээг бий болгож байна гэсэн тооцоо бий. Шинжээчдийн тооцоолсноор дэлхийн газрын тосны одоо илрээд буй нөөц 30 гаруйхан жил хүрэлцэх хэмжээнд буй аж. Үүнээс үүдэн хөгжингүй улс орнууд дараагийн энергийн эх үүсвэрийг орлох нүүрс, уранд ихээхэн анхаарал хандуулж эхэллээ. Уран нь аюултай боловч энергийн ихээхэн ирээдүйтэй, өртөг багатай эх үүсвэрт тооцогддог. Харин нүүрсний хувьд шатахуун, эрчим хүч гаргаж авах найдвартай, аюулгүй эх үүсвэр юм. Өөрөөр хэлбэл, уран болоод нүүрс нь хөгжингүй гүрнүүдийн энергийн хомсдлыг шийдвэрлэх гарцын нэгэнд зүй ёсоор тооцогдож байна. Цаашдаа энэхүү энергийн хомсдол нь ирээдүйд ямар улс, бүс нутаг дэлхийн улс төр, эдийн засагт хяналтаа тогтоох вэ гэсэн далд өрсөлдөөнийг бий болгож байна.

Зэс нь электроникийн үйлдвэрлэлийн салбарын хамгийн эрэлт хэрэгцээтэй өнгөт металл.

Чухамдаа дээрхи эрдэс баялгийн төлөөх өрсөлдөөн л Монголын нүүрс, уран болон зэсийн дэлхийн зах зээл дээрхи бодит эрэлт,

хэрэгцээг нэмэгдүүлж байна. Бүс нутгийн Япон, Солонгос зэрэг орон нүүрс, шатахууны дийлэнхи хэрэгцээгээ Африк, Латин Америкийн орнууд, Австралиас асар өндөр өртөгөөр хангаж байна. Хятад ч гэсэн сүүлийн үед Казакстан, Ойрхи Дорнод, Африкт ихээхэн анхаарал хандуулах болов. Хятад, Япон, Солонгосын хувьд өртөг багатай гуравхан зах зээл бий. Энэ нь ОХУ, Казакстан, Монгол.

Манай орны хувьд газар зүйн байрлалаар илүү ойр, нүүрс, уран, зэсийн асар их нөөцтэй гэдэг утгаараа бүс нутгийн дээрхи орнуудын эрчим хүчний гол нийлүүлэгч хөрш болох, улмаар бүс нутагт эрчим хүчний хямралаас үүдэн гарах уламжлалт бус аюулаас сэргийлэхэд гол үүрэг гүйцэтгэх орон болох боломж бүрэн бий. Ингэснээр ЗХА-ийн бүс нутагт харилцан хамаарал бүхий эдийн засгийг бий болгоход хувь нэмрээ оруулж, байр сууриа бэхжүүлж, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцид нэгдэн орох нөхцөл бүрдэнэ гэж төсөөлж байна. Бүс нутгийн хүчирхэг гүрэн Оросын хувьд энергийн асар их нөөцтэй нь маргаангүй, гэхдээ бүс нутаг төдийгүй дэлхийн хэмжээний эдийн засагтай Хятад, Япон, Солонгос зэрэг орнууд эрчим хүчний хомсдолоо дан ганц Оросоос нөхөж, Оросын хяналтанд байхыг хүсэхгүй нь мэдээж. Оросын хувьд дээрхи орнуудын эрчим хүчний болон аж үйлдвэрийн түүхий эдийн хомсдлыг хангаж, өөртөө хамааралтай байлгах сонирхол бий. Бусдыг энергийн эх үүсвэрээр хэрхэн хянаж болохыг Оросын жишээ тодорхой харуулж байна. ОХУ шатдаг хийн хоолойгоо хаахад л Европын Холбоонд эдийн засгийн хүндрэл үүсч, энэ нь цаашлаад бүс нутгийн хэмжээнд уламжлалт бус аюул нүүрлэж ч болзошгүй болохыг өнөөгийн үйл явцын өрнөлт нотлон харуулж байгаа билээ.

ЗХА-ийг хамарсан эрчим хүчний эх үүсвэрийн хомсдол бий болоод байгаа энэ цаг үед бүсийн орнуудын сонирхол Монголын эрдэс баялгийн нөөцийг ашиглах асуудал дээр төвлөрч, тэдний хооронд хүчтэй өрсөлдөөн явагдаж байна.

Монгол орны байгалийн эрдэс баялгийн нөөцийг ашиглах асуудлыг эдийн засаг, байгаль орчин, нийгэм гэсэн гурван тулгуурт тогтвортой хөгжлийн Рио-гийн болон хүлэмжийн хийн Киото-гийн тунхаглалын үзэл баримтлалын хүрээнд, бүс нутгийн орнуудын хэмжээнд нээлттэй хэлэлцэж, хүрээлэн буй орчны уламжлалт бус аюулгүй байдал болон бусад олон хүчин зүйлтэй нягт холбон цогцоор авч үзэхгүй бол уламжлалт бус олон төрлийн аюул заналыг өөртөө татан дуудаж болзошгүй байдалд байна.

Энд юуны өмнө туйлын эмзэг, өвөрмөц тогтоц бүхий Монгол орны экосистем өртөхөөр байна. Цаашлаад бүс нутгийн орнуудын геополитикийн сонирхол ч хүчтэй нөлөө үзүүлэх хандлага ажиглагдах болов.

Дээрхи үйл явцын өрнөлт нь ардчилал, зах зээлийн эдийн засгийг сонгоод 18 дахь жилтэйгээ золгож буй Монгол орон өнөөдөр байгалийн эрдэс баялгийнхаа асар их нөөцийн улмаас дахин бүс нутгийн их гүрнүүдийн эрх мэдэл, эдийн засгийн ашиг сонирхолын объект болж, уламжлалт бус аюулын нэгэн голомт болж болзошгүй нь гэсэн эмзэглэл төрүүлж байна.

Монгол орны хосгүй авч өртөмхий эмзэг экосистемд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт хүчтэй нөлөө үзүүлэх боллоо. Ялангуяа эдийн засгийн үндсэн салбар болсон бэлчээрийн мал аж ахуйд бүр ч хүндээр тусч байна.

Монгол орон ган гачигийн улмаас цөлжилтөнд хүчтэй нэрвэгдэж гэнэтийн шороон болон цасан шуурганы аюулд хүн, мал ихээхэн өртөж, түүний давтамж ч нэмэгдэх боллоо. Манай орны хувьд энэ гэнэтийн аюул бүс нутгийн орнуудад тохиолдож буй цунами, газар хөдлөлттэй бараг дүйх хэмжээнд хүрээд байна.

Монголын шороон шуурга өнөөдөр Хятад, Солонгос, Японыг дайрч цаашлаад Америк хүрч газарддаг болохыг америкийн болон бүс нутгийн эрдэмтэдийн судалгаа нотолсон билээ. Энэ утгаараа Монголын шороон шуурга, агаарын бохирдол бүс нутгийн орнууд төдийгүй Хойд Америкт ч аюулын харанга дэлдэж эхэллээ.

Энэ мэт экосистемийн хувьд сэтгэл түгшүүлсэн нөхцөл байдал бий болсныг үл харгалзан Монгол орны эрдэс баялгийг ашиглах асуудлыг ганц хоёрхон улс орны хэмжээнд яаран шийдвэрлэж болохгүй биз ээ. Монгол орны эрдэс баялгийг ашиглах асуудлыг уламжлалт бус аюулын хүрээнд бүс нутгийн хэмжээнд олон талаас нь нягтлан авч үзэж, эрдэс баялгийг боловсруулах дүрэм журам, хуваарилалт, байгаль орчны бодлогын асуудлыг цогцоор шийдвэрлэж, Монголын эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж, эрдэс баялгийг иж бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн гаргаж экспортлох стратегийн чанартай орчин үеийн технологитой томоохон үйлдвэр байгуулахад зайлшгүй хэрэгтэй түнш, туслан дэмжигчийг сонгохдоо хүчтэй “гуравдагч” түншийг оролцуулсан тэнцвэртэй, хяналттай, хүлээн зөвшөөрөгдсөн харилцаа, хамтын ажиллагааны үр дүнд л Монголын арвин их эрдэс баялаг хүн ардадаа өгөөжөө өгнө.

Хэрэв энэ үйл явцад хяналт тавьж чадахгүй бол Монголд Боливи, Африкийн гунигт түүх давтагдах, цаашлаад бүс нутгийн хэмжээнд уламжлалт бус аюул занал нүүрлэх магадлал өсөн нэмэгдэнэ. Ийм учраас энэ асуудлаар бүс нутгийн орнуудын дээд хэмжээний уулзалт зохион байгуулан хэлэлцвэл илүү үр дүнтэй шийдэлд хүрнэ гэдэгт итгэлтэй байна.

Уламжлалт бус глобал аюултай холбогдуулж тэмдэглэхэд, манайд энэ төрлийн аюулын олон шинж тэмдэг нэгэнт илэрч тэр нь даамжирч шатлан өргөжих хандлагатай болж байгаа нь түгшүүр төрүүлж байна.

Сүүлийн үед хил дамнасан элдэв халдварт өвчний тархалт нэмэгдэж, урд хөршөөс орж ирж буй генийн өөрчлөлттэй ургамлын гаралтай, стандартын бус хүнсний бүтээгдэхүүн хүн амын эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлж байгаа тухай төвийн хэвлэлд байнга мэдээлж байгаа нь ноцтой түгшүүр төрүүлж байна. Түүнчлэн Зүүн Хойд, Зүүн Өмнөд Азийн орнуудын шувууны нүүдлийн гол нутаг болсон Монгол оронд нүүдлийн шувууд элдэв өвчнөөр маш олон тоогоор хорогдох боллоо. Хил дамнасан цагаачлал, шилжилт хөдөлгөөн, хүний наймаа, мансууруулах бодисыг дамжуулан худалдах, ДОХ гэх мэт уламжлалт бус глобал аюул занал Монголд дуулдаж эхэллээ. Энэ мэт нэг орны хэр хэмжээнээс хальж гарсан глобал аюулыг дэлхийн хамтын нийгэмлэг, бус нутгийн орнуудын олон талт нягт хамтын ажиллагааны хүчээр л хязгаарлан тогтоох боломжтой билээ. Тийм учраас Монгол Улс дээрхи асуудлаар бус нутгийн хэмжээнд улам бүр нягт хамтран ажиллахын тулд бүх боломжоо ашиглаж ирлээ. Гэсэн хэдий ч байдал төвөгтэй, түгшүүртэй хэвээр байна.

Дээрхи уламжлалт бус аюул улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалтай ч зарим талаар холбоотой. Өнөөгийн байдлаар Монгол Улсад боловсруулах аж үйлдвэр бараг байхгүй байгаа нь өртөг бий болгож баялаг бүтээх боломжийг хязгаарлаж байна. Үүнээс үүдэн эх орны эрдэс баялаг хүн ардад хүртээл болох нь бага. Хэрэглээний бүх салбарт импорт давамгайлан экспортыг үндсэндээ эрдэс баялгийн түүхий эдээр бүрдүүлж байгаа нь тогтвортой хөгжилд сөрөг нөлөө бүхий олон хүчин зүйлийг бий болгож байна. Монгол Улс ардчилал, нээлттэй зах зээлийн эдийн засагтай орон ч гэлээ бус нутгийн хийгээд глобал гадаад орчноос хол хөндий, худалдаа, эдийн засгийн ямар нэг интеграцид нэгдэж ороогүй дэлхийн цорын ганц ганцаардмал орон болоод байна. Энэ нь санхүүгийн “цунами” болон бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг давхар импортлон авахад хүргэдэг. Дээр нь далайд гарцгүй тул тээврийн зардал асар өндөр тусдаг. Газар зүйн байршлын улмаас худалдааны гол түнш маань хоёр их хөрш болдог. Эрчим хүчний хувьд Оросын, өргөн хэрэглээний барааны хувьд Хятадын хараат байдал байдаг. Гадаад худалдааны эргэлтийн дөнгөж 20 орчим хувь нь ЕХ, АНУ, Японы дунд ногдоно.

Гадаад худалдаагаа мэдэгдэхүйц өргөтгөхгүй бол хоёр хөршөөс хараат байдал нь эдийн засгийн болзошгүй хориг арга хэмжээнд өртөх магадлал өндөр. Энэ мэт зохисгүй байдал нь цаашлаад Евразийн худалдаа-эдийн засгийн дамжин өнгөрөх орны хувиар уламжлалт бус шинэ аюул заналд өртөж ч болзошгүй гэсэн болгоомжлол төрүүлж байна.

Энэ дашрамд тэмдэглэхэд хоёр хөрш маань биднийг нөгөө л хэвшсэн, улиг болсон ойлголтын хүрээнд авч үзэж Орос, Хятадын бүс

нутгийн хил орчмын бүсүүдтэй худалдаа-эдийн засгийн талаар түлхүү хамтран ажиллахыг санал болгож байгаа нь гайхаш төрүүлж байна. Хоёр хөршийн энэ хандлага нь үйл явцын өнөөгийн өрнөлт, хувьсал өөрчлөлт, глобал гадаад орчны талаас нь авч үзэх юм бол өрөөсгөл бодлого төдийгүй хоёр хөршийн Монголтой харилцах харилцааг шинэ шатанд гаргаж огцом урагшлуулах зүтгүүр болж чадахгүй гэдгийг Москва, Бээжин хоёр ухаарч, Монголын талаархи хэвшмэл үзэл баримтлалаа эргэн харж, өөр өнцөгөөс нь харах цаг үе болсон л баймаар юм.

Дээр өгүүлснээ хураангуйлан дүгнэж хэлбэл Монгол орны эрдэс баялгийн асар их нөөцийг ашиглах асуудлыг бүс нутгийн уламжлалт бус аюул, бүсийн худалдаа-эдийн засгийн интеграц, уур амьсгалын дулааралт, байгаль орчны өөрчлөлт зэрэг өргөн цар хүрээнд глобал гадаад орчинтой нягт холбон авч үзүүштэй санагдана. Чухам ийм учраас Монголын эрдэс баялгийн ашиглалтанд бүс нутгийн орнуудын тэнцвэртэй, хяналттай, харилцан хамааралтай хамтын ажиллагааны механизм бий болгох нь Монгол Улсын төдийгүй бүс нутгийн тогтвортой хөгжил цэцэглэлт, глобал аюулгүй байдалд ч чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Хамтарсан Засгийн газрын Хамтран ажиллах Гэрээнээс үзэхэд хүн бүрт 1.5 сая төгрөг өгөх популист амлалтаа хэрэгжүүлэхийн тулд эрчимтэй хөгжих хоёр тулгуурт бодлого, үйл ажиллагааг туйлын зорилт болгосон байх юм. Зүй нь эдийн засаг, байгаль орчин, нийгэм гэсэн дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн гурван тулгуурт тэнцвэртэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж улс орноо эрчимтэй хөгжүүлэх тухай үг, өгүүлбэр олж харсангүй. Тэнцвэртэй хөгжлийн үндэс, амин сүнс нь цэвэр үйлдвэрлэл, байгаль орчинд халгүй цэвэр технологи гэдэггүйсэн бил үү. Гэтэл хамтран ажиллах Гэрээнээс харахад Монгол орны эрдэс баялгийг эрчимтэй ашиглаж, экспортлож байж л эрчимтэй хөгжинө гэсэн санаа агуулсан байх юм.

Бид дэлхийн хэмжээний стратегийн ач холбогдол бүхий байгалийн эрдэс баялгийг ашиглахдаа гурав дахь хөрш Казакстанаас жишээ авмаар юм их байгаа мэт санагдана. Казакстаны эрчим хүчний нөөц баялаг өнөөдөр Казакстаны гадаад бодлогын маш чухал хүчин зүйл болж бүс нутагтаа эрчим хүчний хяналт тогтоож Орос, Хятад, АНУ, ЕХ болон лалын ертөнцтэй харилцах харилцааг тэнцвэржүүлж чадаж байна. Жишээ нь Казакстаны Орос, Хятадтай тогтоосон ойр дөт түншийн харилцааг Америк, ЕХ, лалын ертөнц ямарч хардлага сэрдлэггүй хүлээн зөвшөөрч байна. Казакстан өнөөдөр олон туйлт гадаад бодлогоо хөгжлийн зүтгүүр болгон ашиглаж, эрчимтэй хөгжиж чадаж байна. Бид эрчим хүчний эрдэс баялгийн асар их нөөцөө

Казакстан шиг гадаад бодлогодоо ашиглаж яагаад болохгүй гэж. Ядахдаа бүс нутгийн хэмжээнд явуулах бодлогодоо ашиглах шинэ нөхцөл боломж бүрдсэн гэж үзэж байна.

Чухамжүү энэ үүднээс авч үзвэл глобалчлал, глобал гадаад орчны өнөөгийн хувьсал өөрчлөлтийн явцад ЗХА дахь эрх мэдлийн шинэ дэглэм Монголд хэрхэн нөлөөлж болох вэ гэдэг асуудал ч хөндөгдөх нь мэдээж.

Монгол Улс 1990 оноос дотооддоо ардчилсан хөгжлийг дэмжиж, бүс нутагтаа энх тайван, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн гадаад бодлогын үзэл баримтлалаа томъёолж, энэхүү зорилтоо хэрэгжүүлэхдээ их гүрнүүдтэй харилцаж хамтран ажиллахын зэрэгцээ бүс нутгийн хийгээд бусад орнуудтай хоёр болон олон талт харилцааны нягт сүлжээ бий болгохын төлөө хүчин чармайлт тавин ажиллаж ирлээ.

Монгол Улс “Гуравдагч хөрш”-ийн үзэл баримтлалын хүрээнд ЗХА-ийн Япон, Өмнөд Солонгос, бүсийн гадна АНУ, ЕХ болон бусад орнуудтай харилцан ашигтай, эрх тэгш хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлж байна.

Монгол Улсын гадаад бодлогын дээрхи үзэл баримтлал олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, хүчний тэнцвэрийг хадгалахад үр нөлөөтэй арга хэрэгсэл болж чадаж байгаа гэж бид үздэг.

Хятад, Оросын геостратегийн хүчний төвд, Төв Ази хийгээд Дундад Азийн лалын орнуудтай орон зайн хувьд ойр дөт өвөрмөц байрлалтай, ЗХА-ийн жижиг орон Монгол Улс бүс нутгийн хэмжээнд өрнөж буй өнөөгийн үйл явц, тэнд нүүрлэж буй уламжлалт бус аюул заналыг зайлуулахад ямар үүрэг гүйцэтгэж болохыг тал бүрээс нь харж, шинээр авч үзмээр санагдана. Үүний тулд эхлээд бүс нутгийн орнууд Монголын талаархи хэвшмэл ойлголтоо өөрчлөхөөс эхлэх хэрэгтэй болов уу.

ЗХА-д өрнөж буй өнөөгийн үйл явц энэ бүс нутагт уламжлалт бус аюулгүй байдлын хамтын ажиллагааны шинэ бүтэц, механизм яаралтай бий болгох явдал юу юунаас чухал байгааг харуулж байна.

Монгол Улс хэдийгээр бүс нутгаасаа харьцангуй зайдуу байрлалтай хэдий ч бүс нутгийн уламжлалт бус аюулыг зайлуулахад идэвхитэй оролцож, хүчний харьцааг тэнцвэржүүлэх, хамтын ажиллагааны ийм бүтэц бий болгоход бүс нутгийн орнуудад зуучлах замаар харилцаа, хамтын ажиллагааг ургашлуулах, хүчний харьцааг тэнцвэржүүлэхэд нөлөө үзүүлж чадах орны нэг гэж үзнэ.

Монгол Улс өнөөдөр хоёр их хөрш хийгээд гуравдагч хөршүүдтэйгээ харилцааны даацтай суурь үндсийг бүрдүүлж чадсан нь дээрхи үйл явцыг урагшлуулахад нөлөөлөх хүчин зүйлийн нэг болж байгаа юм.

**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

1. “Өдрийн сонин” 2008.03.11,
2. “Стратеги судлал” сэтгүүл. 2007.№4
3. [www.cgdev.org](http://www.cgdev.org)
4. “Washington times” June 25,2008
5. [www.rsis-ntsasia.org](http://www.rsis-ntsasia.org)
6. [www.asiasociety.org](http://www.asiasociety.org)
7. [www.globaldashboard.org](http://www.globaldashboard.org)
8. [www.wiredforface.org](http://www.wiredforface.org)
9. [www.ced.org](http://www.ced.org)
10. [www.idss-nts.org](http://www.idss-nts.org)
11. [www.usip.org](http://www.usip.org)
12. [www.brookings.edu](http://www.brookings.edu)
13. [www.people.com.cn](http://www.people.com.cn)
14. “Восточно-Сибирская правда” 2008.08.25
15. [www.regnum.ru](http://www.regnum.ru)
16. [www.china-embassy.ch](http://www.china-embassy.ch)
17. [www.asean.economics.com](http://www.asean.economics.com)
18. [www.asean.sec.org](http://www.asean.sec.org)